



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/028/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Монгол Улсын ерөнхий аудиторын

орлогч: Я.Самбууням

Утас:261945 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас:261945 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: В.Эрдэнэцогт

Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn

Ахлах аудитор:М.Пагамдулам

Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn

Аудитор: Ж.Бямбацогт

Утас: 261628 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.25 № 1588
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Т.МӨНХСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 76,995.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд хувийн хэвшлийн эмнэлэгээс авах авлага 102.2 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 75,999.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- Хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, рашаан сувиллын өмнөх онуудаас дамжиж ирсэн урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 94.9 сая төгрөгийг барагдуулаагүй. Үүнээс жилийн эцэст 82.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй;

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, мөн хуулийн 6.2.2 “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын хэмжээнд тайлант онд 46 улсын болон 36 хувийн хэвшлийн эмнэлгээс 218.9 мянган даатгуулагчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлбөрт 36,294.5 сая төгрөгийг нэхэмжилснээс цахим системийн хяналтаар 16.1 мянган хүний 4,695.7 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийг хасаж, 202.8 мянган хүний 31,598.8 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийг олгохоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн даатгалын цахим системийн хөгжүүлэлт шат дараатайгаар хийгдэж, хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн хяналтыг сайжруулах чиглэлээр шинэчлэл хийсний үр дүнд тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 05, 06 дугаар тогтоолын дагуу нийт 141 өөрчлөлт, хөгжүүлэлт хийгдэж, гэрээний мэдээллийг шинэчлэн, кодчлолын өөрчлөлтүүдийг нэвтрүүлсэн, Mongolia академи УҮГ-тай ХҮР системээр дамжуулан мэдээлэл солилцох 16 үйлчилгээ, Монгол улсын донорын хуулын хэрэгжилтийг ханган донорын нэгдсэн сан үүсгэх ажлын хүрээнд 6 үйлчилгээ, жирэмсний хяналтын дэвтрийг цахимжуулах ажилтай холбоотойгоор бүртгэгдсэн мэдээллийг дамжуулах 4 үйлчилгээ, 331 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад амбулаторийн тусламж үйлчилгээг цахим системд нэвтрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

“Хэрэглэгчтэй харилцах төв” үйлчилгээг нэмэгдүүлж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан ёсны цахим хуудсаар дамжуулан даатгуулагч, иргэдэд цахимаар мэдээлэл өгдөг болсноор 2024 оны жилийн эцсийн байдлаар 10654 иргэнтэй цахимаар харьцаж, төрсөн эхийн төр хариуцах 2 жил /ихэр/ бол 3 жил, шинээр төрсөн нярайн овог нэрийг цахим системд бүртгэх, баталгаажуулах үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн байгууллагын пэйж хуудсанд ирсэн 802 иргэний сэтгэгдэл мэдээлэлд хариулт өгч ажилласан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	279,911,793.2	365,968,553.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	161,057,086.6	156,246,469.4
33	АВЛАГА	80,227,268.8	168,799,032.1
34	УРЬДЧИЛГАА	994,251.4	5,168,556.7
35	БАРАА МАТЕРИАЛ	37,633,186.5	35,754,495.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,297,807.8	7,123,811.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,297,807.8	7,123,811.8
39200	Биет хөрөнгө	3,003,936.3	3,323,944.5
39300	Биет бус хөрөнгө	4,293,871.5	3,799,867.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	287,209,601.0	373,092,365.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	218,321,666.5	316,851,358.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	218,321,666.5	316,851,358.4
41300	Өглөг	218,317,261.5	316,844,612.4
41400	Урьдчилж орсон орлого	4,405.0	6,746.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	68,887,934.5	56,241,007.2
51	Засгийн газрын хувь оролцоо	68,887,934.5	56,241,007.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	13,793.9	13,793.9
51200	Хуримтлагдсан үр дүн	68,874,140.6	56,227,213.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ ДҮН	287,209,601.0	373,092,365.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,595,486,473.6	2,118,631,373.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	228,117,403.9	358,312,425.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	228,117,403.9	358,312,425.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,298,800.8	75,363,086.8
120	Нийтлэг татварын бус орлого	2,298,800.8	75,363,086.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,365,070,268.9	1,684,955,861.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,798,390,652.8	2,131,129,181.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,798,390,652.8	2,131,129,181.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,452,605.3	15,702,907.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,197,982.9	8,754,763.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	816,464.8	1,094,886.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	167,094.0	191,660.2
2104	Хангамж, бараа материалын зардал	242,296.8	334,509.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,278.8	49,057.0
2107	Томилолт, зочны зардал	175,686.0	171,625.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,428,164.3	2,992,772.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,384,637.7	2,113,633.5
212	ТАТААС	99,506,508.4	137,801,605.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,686,431,539.1	1,977,624,669.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(202,904,179.1)	(12,497,808.2)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	53,331.0	0.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(202,957,510.2)	(12,497,808.2)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	271,820,253.2	271,820,253.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25,191.5	25,191.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,845,444.7	271,845,444.7
9	Тайлант үеийн үр дүн	(202,957,510.2)	(202,957,510.2)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,887,934.5	68,887,934.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,887,934.5	68,887,934.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(149,119.1)	(149,119.1)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,738,815.4	68,738,815.4
19	Тайлант үеийн үр дүн	(12,497,808.2)	(12,497,808.2)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,241,007.2	56,241,007.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,665,183,839.0	2,085,189,124.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,407,394.0	58,926,733.9
120	Нийтлэг татварын бус орлого	52,407,394.0	58,926,733.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,612,776,445.0	2,026,262,390.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,674,371,400.2	2,088,928,704.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,674,371,400.2	2,088,928,704.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,582,798.3	67,819,914.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,259,244.1	8,756,268.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	787,203.6	1,094,886.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	167,094.0	191,660.2
2104	Хангамж, бараа материалын зардал	213,240.6	221,944.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,653.8	46,954.6
2107	Томилолт, зочны зардал	175,686.7	173,377.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,399,574.7	3,058,011.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,538,100.8	54,276,811.8
212	ТАТААС	89,976,040.8	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,533,812,561.1	2,021,108,790.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(9,187,561.2)	(3,739,580.2)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	121,308.6	1,071,036.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	121,308.6	1,071,036.9
2200	Дотоод эх үүсвэрээр	121,308.6	1,071,036.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(121,308.6)	(1,071,036.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(9,308,869.8)	(4,810,617.2)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	170,365,956.4	161,057,086.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	161,057,086.6	156,246,469.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,933,171,586,500.00	1,931,329,902,780.44	1,841,683,719.56	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,933,171,586,500.00	1,931,329,902,780.44	1,841,683,719.56	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,562,600,000.00	53,562,600,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,562,600,000.00	53,562,600,000.00	0.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,562,600,000.00	53,562,600,000.00	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,863,163,146,800.00	1,862,717,841,407.17	445,305,392.83	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,862,692,266,800.00	1,862,692,266,800.00	0.0	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,862,692,266,800.00	1,862,692,266,800.00	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	470,880,000.00	25,574,607.17	445,305,392.83	5.4
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	470,880,000.00	25,574,607.17	445,305,392.83	5.4
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,445,839,700.00	15,049,458,773.27	1,396,380,926.73	91.5
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,445,839,700.00	15,049,458,773.27	1,396,380,926.73	91.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,600.00	(2,600.00)	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		2,600.00	(2,600.00)	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,964,757,300,000.00	1,921,720,970,908.09	43,036,329,091.91	97.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,070,917,800,000.00	1,070,917,755,900.00	44,100.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,070,917,800,000.00	1,070,917,755,900.00	44,100.00	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	893,839,500,000.00	846,839,212,033.76	47,000,287,966.24	94.7
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	893,839,500,000.00	846,839,212,033.76	47,000,287,966.24	94.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.0	3,964,002,974.33	(3,964,002,974.33)	100.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	3,964,002,974.33	(3,964,002,974.33)	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	151,457,086,571.16		100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	146,271,502,665.96		100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	0	100.0
610001	Төсвийн байгууллага	3	3	0	100.0

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	285	285	0	100.0
620001	Удирдах ажилтан	38	38	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	232	232	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	15	15	0	100.0
620004	Гэрээт ажилтан	0	0	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		105,081,050,177.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ		105,081,050,177.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		574,804,729.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		168,388,338.21
210101	Үндсэн цалин		17,400,979.21
210102	Нэмэгдэл		150,987,359.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		18,144,656.26
210201	Тэтгэврийн даатгал		1,212,580.62
210202	Тэтгэмжийн даатгал		16,932,075.64
2107	Томилолт, зочны зардал		29,689,900.00
210702	Дотоод албан томилолт		29,689,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		85,724,567.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		85,724,567.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		272,857,267.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		156,191,267.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		116,666,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		104,506,245,448.16
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		104,082,931,599.16
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		104,082,931,599.16
2132	Бусад урсгал шилжүүлэг		423,313,849.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		423,313,849.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		105,456,016,927.23
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		105,456,016,927.23
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		538,729,211.47
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		104,652,037,248.16
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		265,250,467.60
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		374,966,749.80

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,283.7 сая төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд: Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан 103.4 сая төгрөгийн 1 алдаа, буруу тусган илэрхийлсэн 4,180.3 сая төгрөгийн 4 алдааг залруулсан.

Аудитаар нийт 76,995.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 175.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлж, 76,820.1 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Нийт 76,995.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,402.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,283.7 сая төгрөгийн алдааг залруулж, 57.1 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 61.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 76,877.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 118.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 76,758.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлээ.

3.2.1 Албан шаардлага

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгжээс тавих хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 4,402.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4,283.7 сая төгрөгийн алдааг залруулж, 57.1 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 61.4 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.10-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлд суурилсан шалгалтын төлөвлөгөө батлуулж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, зөрчлийг 20.0-оос доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Капитал банкны авлага 75,999.9 сая төгрөг, хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, рашаан сувиллын өмнөх онуудаас дамжиж ирсэн урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 94.9 сая төгрөгийг барагдуулаагүй, тайлант онд хувийн хэвшлийн 8 эмнэлэгээс авах авлага 102.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс жилийн эцэст 82.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Он дамжсан авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ажлыг дэс дараатайгаар зохион байгуулах.

Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал.

Илрүүлэлт:

2. ЭМД-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 507.8 сая төгрөгөөр тасарч тус сангийн үйл ажиллагааны зардлаас иргэн, ААНБ-д мэдээ, мэдээлэл түгээх, сурталчилах үйл ажиллагаанд 561.7 сая төгрөгийг зарцуулсан нь үр дүн муутай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", мөн хуулийн 14.2.11 "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд эрүүл мэндийн даатгалын талаар мэдээ, мэдээллийг түгээх, сурталчилах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, даатгалд хамрагдалтын тоог нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

3. ЭМД-ын сангаас 1 иргэнд үзүүлэх үйлчилгээний мөнгөн дүнгийн дээд хэмжээ 2.0 сая төгрөгийг хүчингүй болгож, хязгаар тогтоогоогүйгээс орлого зарлагын тэнцэл алдагдах эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", мөн хуулийн 6.2.2 "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", Тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 "төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ЭМДС-ийн орлого, зардал, эмнэлгийн тусламж үйлчилгээний бүтцэд дүн шинжилгээ хийж дүгнэлт гарган дээд шатны байгууллагад танилцуулах

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орихигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл	1	0.9	-	-	1	0.9	1	0.9	-	-	-	-
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	4	4,282.8	1	103.4	3	4,179.4	4	4,282.8	-	-	-	-
Нийт дүн		5	4,283.7	1	103.4	4	4,180.3	5	4,183.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сан	4	76,877.2			1	118.5	3	76,758.7					
2	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл	3	65.0			1	12.5	2	52.5					
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	5	53.5			3	44.6	2	8.9					
Нийт дүн		12	76,995.7			5	175.6	7	76,820.1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс												
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сан	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
2	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл			-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар			-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн		1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-